



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 23 өдөр

Дугаар 1177

Хужирт сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус суманд хийгдсэн “Золбин нохой устгах” ажлыг хүлээж авах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.


Ажлын хэсгийн ахлагч: Б.Бямбасүрэн - Байгаль орчны асуудал хариуцсан
мэргэжилтэн

Гишүүд: Д.Мягмарсүрэн – 4 дүгээр багийн Засаг дарга

Ц.Лхамролом – 5 дугаар багийн Засаг дарга

2. Дээрх ажлыг техникийн тодорхойлолт, гэрээний дагуу хүлээж авахыг ажлын хэсэг, ахлагч (Б.Бямбасүрэн)-д даалгасугай.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ДЭМБЭРЭЛ